

“ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ” ТӨҮГ-ЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2018/17/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 99032466
Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 89148989
Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Ай Жэй Эй Эйч аудит ХХК-ийн захирал Г.Энхмаа
Утас: 99040059 450279
Цахим хаяг: Enkhmaa_56@yahoo.com

Чанарын хяналтын мэргэжилтэн Л.Оюунцэцэг
Утас: 99073014
Цахим хаяг: oyuntsetsegl@yahoo.com

Аудитор Г.Бэлэгт
Утас: 99088333
Цахим хаяг: g_belegt@yahoo.com

Улаанбаатар хот
2018 он



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	Error! Bookmark not defined.
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн 7	
2.5	Дотоод хяналт	7
2.7	Авлага, өр төлбөр, түүний талаарх тайлбар.....	8
2.8	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.9	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	9
2.10	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	10
2.10.1	Авлага, өр төлбөрийн талаар	10
2.10.2	Татварын өглөгийн үлдэгдлийн талаар	10
2.11	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.12	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	10
2.13	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	10
2.14	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	10
2.16	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
3.1	Авлага, өр төлбөрийн талаар	13
3.2	татварын өглөгийн үлдэгдлийн талаар	14
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	15
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2	Аудит хийгдсэн орлогын тайлан	17
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	19





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018. 03. 14 № 06/663
танай _____ -ны № _____ -г

“ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ”
ТӨҮГ-ЫН ДАРГА Ө.ОЮУНБААТАР
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0315SAG87.Docx

071254

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0315SAG87.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

1 Аудитын тайлан

1.1 Оршил

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын захирал Ө.Оюунбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг ба материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд тайланд тусгагдсан өр авлагыг тооцоо нийлэн актаар баталгаажуулаагүй, худалдан авсан шатахуун, сэлбэг хэрэгслийг данс бүртгэлд тусгалгүй шууд зардлаар тайлагнасан, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрсөн зэрэг зөрчилд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн төв лаборатори ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ. Код: САГ-2018/17/СТА-ТӨҮГ


Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дүгээр сарын 23-наас 2018 оны 03 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын удирдлагад хүргүүлэхээр



төлөвлөн, “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн аудитор Г.Бэлэгт, аудиторын туслах Я.Чинцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 02 сарын 15-ны 291 тоот албан тоотоор Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д ирүүлсэн боловч бусад шаардлагатай мэдээ судалгааг хугацаанд нь өгөхгүй сүүлийн баримт материалыг 3 сарын 15-нд ирүүлсэн.


1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, “Стандартчилал тохирлын үнэлгээний тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ААНОАТ-ын тухай хууль, НӨАТ-ын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, ХХОАТ-ын тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, СТОУС зэрэг эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ -ын үйл ажиллагааны үндсэн зорилт нь Монгол Улсын эрдсийн түүхий эдийн шинжилгээний үнэн, зөв, баталгаатай үр дүнгээр захиалагч, үйлчлүүлэгчийг хангахад оршино.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд захиалагчийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Ашигт малтмалын дээжийн физик, механик шинж чанар, үзүүлэлтүүдийг тодорхойлох шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх
- Эрдсийн түүхий эд, цацраг идэвхит ашигт малтмал бусад боломжит материалаар холбогдох стандартад нийцүүлэн захиалагчийн болон өөрийн хөрөнгөөр аттестатилсан, стандартчилсан загвар зохион бүтээх, баталгаажуулах, дотоод гадаадын зах зээлд борлуулах
- Эрдсийн түүхий эд, тэдгээрийн баяжмалд элементийн болон эрдэсийн найрлага, бүтцийг хими, спектор, минералоги, петрограф, минераграф, цөмийн физикийн тоон, хагас тоон болон чанарын шинжилгээг дэвшилтэт арга техник, технологи ашиглан захиалагчийн эрэлт шаардлагад нийцүүлэн өндөр нарийвчлалтайгаар тодорхойлох
- Эрх бүхий төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгжүүдийн ашигт малтмалын олборлолтын явцад хяналтын сорьцлолт, шинжилгээ хийж дүгнэлт зөвлөмж өгөх
- Эрдсийн түүхий эдийн шинжилгээ хийж байгаа лабораториудын шинжилгээний ажилд хяналтын шинжилгээ хийх
- Бараа бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтын сорилт шинжилгээ хийх, хөндлөнгийн хяналт буюу итгэмжлэгдсэн лабораторийн үүргийг гүйцэтгэх
- Лабораторийн шинжилгээний дэвшилтэт арга аргачлал боловсруулж батлуулах
- Төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагийн шугамаар хэлэлцэгдэн дэмжигдсэн гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамтран болон бие даан оролцох
- Лабораторийн шинжилгээ туршилтанд нэвтэрч байгаа дэлхийн улс орнуудын дэвшилтэт аргачлал, техник, технологийг нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлээр гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана” гэж заасны дагуу “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын захирал нь удирдаж эд хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим томоохон дансад түүвэрчилсэн байдлаар нарийвчилсан 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Даймонд” програмаар гүйцэтгэн санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлангаа гаргасан байна.

1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Ингэж хянахдаа “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтыг санхүүгийн, хяналтын эрсдэл байвал зохих горимтой харьцуулан шалгаж үзсэн. Үүний үр дүнд удирдлагаас зайлшгүй хэрэгжүүлэх дотоод хяналт хангалттай байна гэж үзлээ.

2.6 Орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 20-ны өдрийн 236 дугаар тогтоолоор “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан байна.



2017 оны жилийн эцсийн аудит хийгдсэн
зорилтот түвшингийн биелэлт

мянган төгрөгөөр

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он		Өөрчлөлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү (3-2)	Хувь (3*100/2)
А	Б	1	2	3	4	5
Нийт орлого:	мян/төг	2,819,799.8	3,066,599.0	3,426,931.2	360,332.2	111.8
Үүнээс: Цэвэр борлуулалт	мян/төг	2,574,359.5	2,848,774.0	3,219,385.2	370,611.2	113.0
Нийт зардал:	мян/төг	3,665,001.1	3,048,230.6	3,107,847.2	59,616.6	102.0
Үүнээс: удирдлагын зардал	мян/төг	478,005.4	328,787.0	267,682.4	(61,104.6)	81.4
Татварын өмнөх ашиг / алдагдал /	мян/төг	(845,201.3)	18,368.4	319,084.0	300,715.6	1,737.1
Цэвэр ашиг / алдагдал /	мян/төг	(845,201.3)	7,926.6	279,141.0	271,214.4	3,521.6
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	Төгрөг	1.30	0.99	0.91	(0.09)	8.8
Нийт авлага	мян/төг	1,207,280.20	889,055.4	1,383,328.60	494,273.2	(55.6)
Нийт өр төлбөр	мян/төг	1,681,758.40	1,538,853.7	1,229,831.44	(309,022.3)	20.1
Үүнээс: Богино хугацаат өр	мян/төг	1,572,890.30	1,442,953.7	1,229,831.44	(213,122.3)	14.8
Урт хугацаат өр төлбөр	мян/төг	108,868.10	95,900.0	-	(95,900.0)	100.0
Хөрөнгө оруулалт, их засвар	мян/төг	115,376.30	346,990.00	39,642.70	(307,347.3)	88.6
Ажиллагсдын тоо	хүн /тоо	173.00	158	158.00	-	-
Цалингийн сан	сая.төг	1,582,958.10	1,650,056.0	1,649,579.90	(476.1)	0.0

Тайлант жилд зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөө 111.8%-иар биелж 11.8%-иар давуулан биелүүлсэн байна. Зарлагын төлөвлөгөө 102%-ийн гүйцэтгэлтэй гарч 59.6 сая төгрөгөөр хэтэрсэн байгаа боловч орлогын төлөвлөгөө давж биелсний улмаас **279.1 сая төгрөгийн ашигтай** ажилласан байна.

Тайлант онд өмнөх оноос 1,124.3 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 271,2 сая төгрөгөөр илүү ашиг олжээ.

Тус байгууллага нь тайлант онд борлуулалтын орлогоо 13 хувиар давуулан биелүүлсэн байгаа бөгөөд ажил үйлчилгээ ихэссэнтэй уялдаж түүхий эд материалын, цахилгааны, усны зардлууд өсөж зардал төлөвлөсөн хэмжээнээс 2 хувиар хэтэрсэн үзүүлэлттэй гарсан байна.

1.7 Авлага, өр төлбөр, түүний талаарх тайлбар

а/ Авлагын талаар

Тус лаборатори нь 2017 оны эхэнд 1,194.6 сая төгрөгийн авлагатай байсан бөгөөд тайлант онд 224.9 сая төгрөгийн авлага барагдаж 378.0 сая төгрөгийн авлага нэмэгдэж 1,360.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэгдсэн авлага нь:

- Эрдэнэс таван толгой ХК-аас зарласан тендерийн баталгаа ХХБ-д байршуулсан 121.3 сая төгрөг
- Оюу толгой ХХК-ийн 11, 12 дугаар сарын шинжилгээний ажлын төлбөр 214.5 сая төгрөг
- Гаалийн төв лабораториос шинжилгээний ажлын төлбөр 27.1 сая төгрөг
- Төсвийн хөрөнгөөр санхүүжигдэн хийгдэж буй геологи хайгуулын компаниудын гэрээт ажлын төлбөр 117.3 сая төгрөг байна.

Оюу толгой ХХК нь өдөр бүр дээжний шинжилгээний ажил гүйцэтгэх бөгөөд ажлын төлбөрийн нэхэмжлэхээ сар бүрийн эцэст нэгтгэж нэг авдаг ба нэхэмжлэхээс хойш 45 хоногийн дараа төлбөр төлнө гэж гэрээнд заасныхаа дагуу төлдөг юм байна.

Үүний улмаас тайлант хугацааны сүүлийн 2 сарын шинжилгээний ажлуудын гүйцэтгэл нь санхүүгийн тайланд авлагаар тусгагдаж гарчээ.

Төсвийн хөрөнгөөр санхүүжигдэн хийгдэж буй геологи хайгуулын ажил ихсэхийн хирээр тайлант хугацааны авлага нэмэгдэж гардаг юм байна.

Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл 9.9 сая төгрөгөөр барагдаж тайлант хугацааны эцэст 21.2 сая төгрөгийн түүхий эд материал болон сэлбэг хэрэгслийн төлбөрийг Хятадын болон дотоодын компанид төлөөд бараагаа авч чадаагүй тул үлдэгдэл 23.0 сая болжээ.

б/ Өр төлбөрийн талаар

Тайлант оны эхэнд 1,572.9 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд тайлант хугацаандаа Хөгжлийн банкнаас авсан 108.9 сая төгрөгийн урт хугацаат зээл, Голомт банкнаас сар бүр ажилтнуудынхаа цалинг тавихаар авч байсан 120.0 сая төгрөгийн овердрафтын зээл болон НДШ-ийн 155.3 сая төгрөгийн өрийг барагдуулан оны эцэст 1,229.8 сая төгрөгийн өртэй гарчээ. Энэхүү өрийн үлдэгдлийн 481.7 сая төгрөг нь урьдчилж орсон орлого байгаа ба энэ нь төлбөр нь ороод шинжилгээний ажлын захиалга тавигдсан болон ажил нь эхэлж байгаа ажлуудын төлбөр байна.

Тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, ТӨБЗГ-ын 2016 оны 151 тоот тогтоолыг үндэслэн захирлын 2017 оны 3-р сарын 7-ны 61 тоот тушаалаар байгууллагын авлага барагдуулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар өндөр дүнтэй 39 харилцагчийн 997.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар болон төлбөр барагдуулах гэрээгээр баталгаажуулан заримыг шүүхээр шийдвэрлүүлэхээр нэхэмжилж шийдвэрлүүлэх шатандаа явж байна.

2.8 Шилэн дансны мэдээлэл


Засгийн газрын 2014 оны 12 дугаар асрын 15-ны өдрийн 394-р тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журам батлагдсаны дагуу тус байгууллагын вэб сайтад шилэн дансаа нээж мэдээллүүдээ оруулсан байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр
- Гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн нэгтгэсэн мэдээллийг
- Зорилтот түвшний гүйцэтгэлийг
- Хөрөнгө оруулалт
- Худалдан авалт
- Хагас жилийн санхүүгийн тайлан зэргийг шивж оруулсан байна.

2.9 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу 6 дансанд нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.



1.10 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.10.1 Авлага, өр төлбөрийн талаар

Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 376 харилцагчтай холбоотой 363.1 сая төгрөгийн авлага, 94 харилцагчтай холбоотой 99.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, авлага, өр төлбөрийг барагдуулах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөв.

2.10.2 Татварын өглөгийн үлдэгдлийн талаар

Татварын байгууллагын өр төлбөр баталгаажуулсан баримтаар 549.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй боловч санхүүгийн тайланд 529.6 сая төгрөгөөр илэрхийлж 20.1 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн байна.

Шийдвэрлэсэн нь Санхүүгийн тайлангийн "Үнэн зөв" байх батламж мэдэгдлийг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

1.11 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

1.12 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

"Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар орлогын бүрдүүлэлтийг нарийвчлан тооцох горим сорил хэрэгжүүлэх шаардлагатай.

1.13 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

"Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 483.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 2 зөвлөмж өгөв.


1.14 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

"Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 7 зөвлөмж, 1 албан шаардлага, 1 акт өгөгдсөн байна. Өгөгдсөн 7 зөвлөмж, 1 албан шаадлагыг хэрэгжүүлэн ажиллаж 1 актыг 2017 оны 4 сарын 27-нд төлж барагдуулсан байна.

1.15 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

"Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого болон зардлаас материаллаг түвшинг тооцоход материаллаг түвшин



өндөр гарч байгаа тул зөвхөн нийт зардлаас 2 хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

Нийт зардал 3107.8 сая төгрөг бөгөөд 2 хувиар материаллаг байдлыг тодорхойлж, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 62.2 сая төгрөгөөр баталгаажууллаа.

1.16 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

Аудитлагдсан тайланд санхүүгийн тайлан 5 хуудас, хавсралтууд 6 хуудсыг хавсаргав.



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав

.



2.1 Авлага, өр төлбөрийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 376 харилцагчтай холбоотой 363.1 сая төгрөгний авлага, 94 харилцагчтай холбоотой 99.8 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, авлага, өр төлбөрийг барагдуулах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 07 сарын 02-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Найдваргүй авлага үүсэх, алдагдал хүлээх, мөн өр төлбөр нэмэгдэж санхүүгийн чадамж буурах,

Төсвийн захирагчийн хариу

Тайлант онд авлага, өр төлбөрөө бууруулахад онцгой анхаарч 224.9 сая төгрөгийн авлага, 451.9 сая төгрөгийн өглөг барагдуулж ажилласан. Цаашид энэ ажлаа улам эрчимжүүлж ажиллана.



2.2 ТАТВАРЫН ӨГЛӨГИЙН ҮЛДЭГДЛИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Татварын байгууллагын өр төлбөр баталгаажуулсан баримтаар 549.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй боловч санхүүгийн тайланд 529.6 сая төгрөгөөр илэрхийлж 20.1 сая төгрөгийг зөрүүтэй илэрхийлсэн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн "Үнэн зөв" байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Тайлан тэнцэлдээ өр төлбөрөө үнэн зөвөөр тусгах, залруулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 05 сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.


3 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,392,844.10	60,335,251.76
1.1.2	Дансны авлага	1,194,631,715.87	1,360,365,976.64
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,248,347,524.88	1,249,704,443.81
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,648,476.00	22,962,600.35
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,464,020,560.85	2,693,368,272.56
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,580,529,322.88	4,180,597,152.86
1.2.2	Биет бус хөрөнгө	11,188,017.11	8,986,527.68
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,591,717,339.99	4,189,583,680.54
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,055,737,900.84	6,882,951,953.10
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	366,760,192.85	217,485,878.27
2.1.1.2	Цалингийн өглөг	132,113,979.75	-
2.1.1.3	Татварын өр	491,915,618.37	529,566,523.18
2.1.1.4	НДШ-ийн өглөг	156,398,840.83	1,094,172.20
2.1.1.5	Богино хугацаат зээл	120,028,730.90	
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	305,672,906.54	481,684,863.47
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,572,890,269.24	1,229,831,437.12



2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	108,868,125.26	
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	108,868,125.26	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,681,758,394.50	1,229,831,437.12
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч : - төрийн	3,413,613,163.67	3,413,613,163.67
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	773,675,947.28	773,675,947.28
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	878,158,426.75	878,158,426.75
2.3.9	Хуримтлагдсан ашиг	308,531,968.64	587,672,978.28
2.3.10	Тайлант үеийн ашиг	(845,208,660.03)	279,141,009.64
	Өмнөх үеийн ашиг	1,153,740,628.67	308,531,968.64
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,373,979,506.34	5,653,120,515.98
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	7,055,737,900.84	6,882,951,953.10



3.2 Аудит хийгдсэн орлогын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,794,209,263.11	3410260574.74
2	Борлуулалтын өртөг	3,018,265,661.53	2754696568.83
3	Нийт ашиг (алдагдал)	(224,056,398.42)	655,564,005.91
4	Түрээсийн орлого	23,366,000.00	16,575,000.00
5	Хүүний орлого	73,925.90	95,616.78
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
	Орлогын дүн		
9	Борлуулалт, маркетингийн зардал	74,235,013.78	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	403,770,408.44	267,682,437.61
11	Санхүүгийн зардал	-	
12	Бусад зардал	167,885,201.11	80,046,540.66
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,305,828.41	(4,107,094.73)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(1,314,544.60)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(845,201,267.44)	319,084,005.09
19	Орлогын татварын зардал	7,392.59	39,942,995.45
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(845,208,660.03)	279,141,009.64
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(845,208,660.03)	279,141,009.64
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(845,208,660.03)	279,141,009.64
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		




3.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг
1	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,413,613,163.67	773,675,947.28	878,158,426.75	1,361,187,747.42
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл	3,413,613,163.67	773,675,947.28	878,158,426.75	1,153,740,628.67
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(845,208,660.03)
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-		
9	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,413,613,163.67	773,675,947.28	878,158,426.75	308,531,968.64
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
11	Залруулсан үлдэгдэл				
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				279,141,009.64
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт				
15	Зарласан ногдол ашиг				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,413,613,163.67	773,675,947.28	878,158,426.75	587,672,978.28



3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,224,340,916.38	3,405,916,936.10
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,891,971,237.13	3,147,271,725.65
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	930,400.00	
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	331,439,279.25	258,645,210.45
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,135,927,481.79	3,095,334,467.06
	Ажиллагчдад төлсөн	1,287,244,983.59	1,319,565,308.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	352,218,435.00	507,039,152.55
	Бараа материал худалдан авахад төлсөн	781,596,846.03	442,037,924.46
	Ашиглалтын зардалд төлсөн	186,175,299.28	162,623,967.14
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	98,376,940.00	52,419,619.24
	Хүүний төлбөрт төлсөн	53,453,169.43	25,765,576.74
	Татварын байгууллагад төлсөн	219,614,244.46	477,833,114.20
	Даатгалын төлбөрт төлсөн	2,622,574.00	1,005,120.00
	Бусад мөнгөн зарлага	154,624,990.00	107,044,684.73
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	88,413,434.59	310,582,469.04
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	73,925.00	95,616.78
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	73,925.00	95,616.78
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	99,436,384.76	25,731,727.27
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	98,401,384.76	25,731,727.27
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,035,000.00	
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(99,362,459.76)	(25,636,110.49)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,437,948,093.48	480,906,208.50

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГИЙЛТ

	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,437,948,093.48	480,906,208.30
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,432,951,237.32	709,803,064.46
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,432,951,237.32	709,803,064.46
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,996,856.16	(228,896,856.16)
4	Ханшийн зөрүү	1,305,828.41	(4,107,094.73)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,646,340.60)	(4,107,094.73)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,039,184.70	8,392,844.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,392,844.10	60,335,251.76

